




ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ТАЙЛАН

2023



АГУУЛГА

ТҮҮХЭН ЗАМНАЛ	3
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ	4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	7
АРД АПП	7
БАНКНЫ КЛАСТЕР	8
ДААТГАЛЫН КЛАСТЕР	9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР	10
АРД ВЕНЧУРС	11
АРД БИТ	11
IDAX	11
ДАЙВЕРС СОЛЮШНС	11
МЕТАФОРС	12
МОСТ ФИНТЕК	12
ГРЭЙПСИТИ МОНГОЛ	12
ТЭНГЭРЛИГ МЕДИА НЭГДЭЛ	13
НЭГТГЭСЭН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ	14
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ	15
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ - AARD	16
ОРЛОГЫН ТАЙЛАН	17
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	17
ҮНЭЛГЭЭ	18
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	19
АУДИТ	19
ХУВЬЦААНЫ АРИЛЖАА	20

АЛСЫН ХАРАА

Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно.

ЗОРИЛТ



Нэгдсэн Финтек
шийдэл



Бүтээлч түйвээлт ба
тогтвортой өсөлт



Салбаргүй,
цогц шийдэл



Хөрөнгө Оруулагч
Үндэстэн



Олон улсад
гарах

ТҮҮХЭН ЗАМНАЛ



RTO - Урвуу нэгдэл
IPO - Олон нийтэд хувьцаагаа нээлттэй санал болгох

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм Хувьцаа эзэмшигч танаа, Ардын эргэн тойронд - 2023 оны эхний хагас жилд

Юуны өмнө Ард Санхүүгийн Нэгдэл нь Дэлхийн Эдийн Засгийн Форум (ДЭЗФ)-ын "New Champions" буюу "Шинэ Аваргууд" нийгэмлэгт элсэх урилга хүлээн авсныг дуулгахад таатай байна. Энэхүү нийгэмлэг нь дэлхийн 30 гаруй орны 130-аад томоохон компаниас бүрддэг бөгөөд манай гишүүн байгууллагын удирдах баг болон нийт хамт олон ДЭЗФ-ын өргөн цар хүрээтэй мэдлэг, мэдээллийн санд нэвтрэх боломжтой болдог юм байна. Бидний хийж бүтээсэн ажлыг дэлхий үнэлж эхэлж байгаад бид туйлын баяртай байгаа.

Оны эхний хагас дуусах энэ мөчид яг нэг зүйл тодорхой болж байна - бид цар тахал, дайн дажинаас үүдэлтэй сүүлийн хэдэн жил үргэлжилсэн эдийн засгийн хямралыг амжилттай даван туулж чадлаа. Монголын эдийн засаг тогтвортой өсөх замдаа орж, хоёр орон тоотой өсөлтийг үзүүлж эхэлж байгаа бол инфляц нэг орон тоо руу орох төлөвтэй байна (түүхэндээ анх удаа улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.5 ихнаяд төгрөгийн ашигтай гарав). Гадаад өрийн удирдлагыг оновчтой явуулж, гадаад валютын албан ёсны нөөц нэмэгдэж (оны эхнээс 12.1 хувиар өсөж 3.8 тэрбум долларт хүрэв), төгрөгийн ханш тогтворжиж, Монгол Улсын экспортын хэмжээ өссөөр, төлбөрийн тэнцэл эерэг гарч байна. Бид мөн крипто өвлийг даван туулж чадлаа. Биткойн 30 мянган долларын босгыг даваад явж байгаа бол АрдКойн 25 төгрөг дээр тогтлоо.

Монголын эдийн засаг сэргэхтэй зэрэгцэн крипто өвөл ч дуусч Монголд нүүрлээд байсан эрсдэлийг бид амжилттай даван туулаад зогсохгүй олон улсад ч биднийг харах өнцөг өөрчлөгдсөнийг Евразийн Бичил Санхүүгийн Төвийн стратегийн түншээр ажиллах урилга ирсэн нь нотолж байна. Хамгийн эхэнд Ард Кредит олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүжүүлэгчдээс мөнгө татах боломжтой боллоо. Мэдээжийн хэрэг санхүүгийн тайлангийн аудитаа хийлгэх, хувьцаа эзэмшигчдэдээ тайлагнах нь оны эхний хагаст хийгддэг томоохон ажлын нэг байдаг. Бид ч тайлангуудаа гаргаж, аудитаа хийлгэж, Ард Санхүүгийн Нэгдэл үүсгэн байгуулагдсан 10 жилийн ойтой давхцуулж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн



Чуулганаа хийлээ. Чуулганы үеэр манай компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа зохион байгуулж, тайлангаа танилцуулж, хувьцаа эзэмшигчдэдээ АрдКойны урамшууллыг хувь тэнцүүлэн олгов.

Түүнчлэн, яг нэг жилийн өмнөөс эхлүүлсэн бүтцийн оновчлолын хүрээнд Компани хоёр тусдаа үйл ажиллагаатай Ард Санхүүгийн Нэгдэл болон Ард Венчурс болон хуваагдах зарчмын шийдэлд хүрэв. Банкны, Хөрөнгө оруулалтын банкны болон Даатгалын кластерт багтах Ард Кредит, Ард Актив, Ард Лизинг, Ард Секюритиз, Ард Менежмент, Ард Пропертиз, Ард Даатгал, Ардын Тэтгэврийн Сан компаниуд болон Үндэсний Хувьчлалын Сан, Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангууд Ард Санхүүгийн Нэгдэлд үлдэж байгаа бол нөгөө талд нь Грэйп Сити, МОСТ Финтек, КриптоҮндэстэн,

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, Монгол Шуудан зэргийг Ард Венчурс компанид харьяалуулж эхэллээ.

МОСТ Финтек рүү СКОПА төслийг харьяалуулж, Харилцагчийн үйлчилгээний төвийг шилжүүлэх ажлууд үргэлжлэхийн зэрэгцээ Грэйп Ситигийн хувьд АрдШоолыг өөртөө нэгтгэж, ЭнЭсПиГи гэдэг компаниар дамжуулан ажиллахаар болж байна.

Үүний хажуугаар Ард Санхүүгийн Нэгдлийн удирдлагын оновчлол, үр ашгийг дээшлүүлэх ажлууд хийгдсээр байна. Группын ТУЗ-ийн даргаар ажиллаж ирсэн П.Батбаяр Азийн Хөгжлийн Банкинд ажиллах болсноор Ч.Ганхуягт ТУЗ-ийн даргын үүрэг ногдохын зэрэгцээ Ард Венчурсыг хэсэгтээ удирдах болов. Группын Санхүү Эрхэлсэн Захирлаар ажиллаж ирсэн Б.Золбоо Ард Санхүүгийн Нэгдлийг удирдахаар томилогдов.

Бид 2023 оны хоёрдугаар хагаст хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг хамгаалах, дээшлүүлэх саналыг гаргахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Ард Венчурс урвуу нэгдэл хийх замаар олон нийтийн компани болж, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчдэд хувь тэнцүүлэн хувьцаагаа санал болгох болно.

2023 оны хоёрдугаар улиралд бид Ардын Тэтгэврийн Дансыг мөн урвуу нэгдэл хийх замаар олон нийтийн компани болох төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлэв. Ингэснээр Монголын ууган тэтгэврийн сан нэг компанийнх бус олон нийтийнх, түүн дотроо тэтгэвэр эзэмшигчдийнхээ мэдэлд очих юм.

Бид үл хөдлөх хөрөнгийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийж, Блю Скай Тауэрын 9 давхрыг бүхэлд нь худалдан авч, ХасБанкинд түрээслүүлэв. Энэхүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхдээ бид банкны зээл ашигласан боловч хажуугаар нь Монголд анх удаагаа үл хөдлөх хөрөнгийг токенжуулж арилжаанд оруулсан онцлогтой. Ард Пропертиз нь Хөх Тэнгэр Төслийг удирдаж, 9 давхар төдийгүй 11 давхрыг түрээслүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Ард Даатгалын хувьд бүх түүхийнхээ хамгийн өндөр борлуулалттай хагас жил боллоо.

АрдКидс - Монголын анхны хүүхдийн санхүүгийн аппликэйшн өдгөө 50 мянга гаруй хэрэглэгчтэй боллоо. #БидИлүүБайжЧадна хөдөлгөөнийг өрнүүлж Монголын бүх үрсэд Ардын хувьцаа эзэмшүүлэх, АрдКойноор мялаах ажил эхлээд явж байна. Энэхүү аян нь Монголын 0-18 насны бүх хүүхэд Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа, АрдКойныг үнэ төлбөргүй эзэмших онцгой боломжийг олгож байгааг онцлон дурдахыг хүсэж байна.



МОСТ Финтек компанийн IPO хийх зөвшөөрлийн хүсэлтээ СЗХ-нд (Санхүүгийн Зохицуулах Хороо) илгээсэн ба энэ нь UBХ (Улаанбаатар Үнэт Цаасны Бирж) дээр хийгдэх анхны IPO болж түүхэнд үлдэх юм. Нэмж дурдахад, Монголын анхны хамтын биржээр арилжаалагддаг сан буюу ETF UBХ дээр бүртгэгдлээ. Бид IPO хийсэн банкууд руу Нэгдлийн хэмжээнд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд цаашид стратегийн хөрөнгө оруулалт байдлаар хандаж төвлөрүүлэх ажлыг хийх юм.

Ард Аппын 5 дугаар хувилбарыг гүйцэлдүүлж, лоттоныхоо аппыг хөгжүүлж дуусгалаа. Түүнчлэн, СКОПА төсөл, Ардын Брокер, Ардын Элч хөтөлбөр, Кредит карт зэрэг томоохон төслүүд ахиц дэвшилтэй урагшилж байна. Үүний зэрэгцээ АрдКредит нь нийт 5 тэрбумаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, СЗХ-нд шинэ хувьцаагаа гаргаж, FPO хийх зөвшөөрлийн хүсэлтээ гаргав. Метафорс компанитай хамтран хэрэгжүүлсэн Хү хамтлагийн метавёрс дэх тоглолтыг зохион байгуулав.

ICT Exro, Монголын Эдийн Засгийн Чуулган, Үндэсний Мэтгэлцээний Лиг, Жюю Жицүгийн Дэлхийн Аваргыг ивээн тэтгэж ажиллалаа. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хөгжлийн ялгаатай хүүхдүүдийн ирээдүйн сайн сайхны төлөө Ирээдүйн Эзэн - Хүүхдийн хадгаламж эзэмшигч болгож, Ардын хувьцаа болон АрдКойн бэлэглэсэн нь нийгмийн тэнцвэртэй, хүртээмжтэй байдлын төлөөх бидний хичээл зүтгэл юм шүү.

Бид хувьцаа эзэмшигчдэдээ тогтвортой үнэ цэнийг тогтмол бүтээж, Монгол Улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө зүтгэсээр байх болно. Хүчтэй. Хамтдаа.

Хүндэтгэсэн,

Хутагт овогтой Чулууны Ганхуяг
ТУЗ-ийн Дарга

Батбилэгийн Золбоо
Гүйцэтгэх Захирлын Түр Орлон Гүйцэтгэгч

IҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Ард Апп

Ард Аппын V5 шинэ хувилбарыг Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2023 Чуулганаар олон нийтэд танилцуулснаар хуучин хувилбарыг 2023 оны III улиралд багтаан бүрэн унтраахаар төлөвлөж байна. Шинэ хувилбар нь хэрэглэгч-харилцагч танд илүү хүртээмжтэй-ээлтэй байхад онцгой анхаарч, олон төрлийн шинэчлэлүүдийг хийлээ. Тухайлбал,



Функц

UI/UX дизайны бүрэн шинэчлэлт

Хэрэглэгчид хоорондоо чатлах, төгрөг болон АрдКойныг чатаар шилжүүлэх

Аппаа өөрийн хүссэн өнгөөр солих

Fast Cash онлайн зээлийн үйлчилгээний бүрэн шинэчлэлт

Кредит картны үйлчилгээ

Үйлчилгээ

Цахим тасалбар худалдааны ticket.mn платформ

Шамбала - 2056 төсөлтэй хамтран Ард Аппаар мод тарих үйлчилгээ

Emch App - Цахим үзлэг, оношилгооны платформ

2022 Н1

1 сая

нийт бүртгэлтэй харилцагч

₮41.5

тэрбум цахим зээл

₮4.2

тэрбум хадгаламж

₮9.6

тэрбум үнэт цаасны арилжаа

₮218.5

тэрбум шилжүүлэг

2023 Н1

1.1 сая

нийт бүртгэлтэй харилцагч

₮30.1

тэрбум цахим зээл

₮10.9

тэрбум хадгаламж

₮8.3

тэрбум үнэт цаасны арилжаа

₮186.1

тэрбум шилжүүлэг

БАНКНЫ КЛАСТЕР

Ард Кредит

Ард Кредит ХК нь ББСБ-ын салбарын анхны карт гаргагчийн зөвшөөрөл авч, Кредит картаа олон нийтэд амжилттай танилцуулж, өнөөдрийн байдлаар 200 гаруй хэрэглэгчид 800 гаруй сая төгрөгийн зээлийн шугам нээсэн байна.

Тогтвортой, ногоон зээлээр багцаа төрөлжүүлэх зорилгоор "Да Хүрээ" автомашины захын дэргэд PHYGITAL (биет болон дижитал хосолсон) салбараа нээв. ЖДҮ-ийг дэмжих бодлогоо үргэлжлүүлж, Интернет Банк V1 (e.ard.mn)-ыг хөгжүүлэхийн зэрэгцээ нийлүүлэлтийн гинжин хэлхээний СКОПА төслөө өргөжүүлснээр 3,385 худалдаа эрхлэгчдийг бүртгэж, 2,139 малчдад 4.3 тэрбум төгрөгийн тэжээлийн санхүүжилт олголоо.

Түүнчлэн 5 сард Монтенегро улсын Будва хотод болсон Дэлхийн Бичил Санхүүгийн 25 дахь удаагийн чуулга уулзалтад оролцож, олон улсын 20 гаруй сантай уулзсан бол үргэлжлүүлэн Чех Улсыг зорьж, Европ дахь Монголчуудыг хамарсан Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Праг арга хэмжээг амжилттай зохион байгуулав.



Ард Актив

Нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оны эцэст 31.5 тэрбум төгрөг байсан бол энэ оны эхний хагас жилд 34.9 тэрбум төгрөг болж өссөн бөгөөд хөрөнгийн хэмжээгээрээ Монгол Улсын хадгаламж, зээлийн хоршоодын дунд хоёрдугаарт бичигдэж байна. Цэвэр зээлийн багцаа 2.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 27.9 тэрбум төгрөгт, эх үүсвэрийн хэмжээг 24.8 тэрбум төгрөгт хүргэснээр эхний хагас жилд 250.9 сая төгрөгийн ашигтай ажиллах боломжийг бий болгов.

Хүүхэд бүхэнд гэрэлт ирээдүйг бүтээх зорилготой Ирээдүйн Эзэн хүүхдийн хадгаламж эзэмшигчид 522-1,542 болон 3 дахин өссөн нь нийгмийн сайн сайхны төлөөх #БидИлүүБайжЧадна аяны бодит нөлөө юм.


(мянган төгрөг)	Гол үзүүлэлт	2022 Н1	2023 Н1	ҮоҮ
Ард Кредит	Нийт зээлийн багц	41,583,197	44,085,706	6.0%
	Цэвэр хүүгийн орлого	2,535,758	2,705,841	6.7%
	Цэвэр ашиг	661,630	1,005,778	52.0%
Ард Актив	Нийт хөрөнгө	28,712.4	34,902.5	21.6%
	Нийт эздийн өмч	7,637.8	8,453.7	10.7%
	Зээлийн багц (цэвэр)	22,479.5	27,939	24.3%

ДААТГАЛЫН КЛАСТЕР

Ард Даатгал

Ард Даатгалын түүхэнд хамгийн өндөр борлуулалттай хагас жил боллоо. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 14.3 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого татан төвлөрүүлсэн нь 2022 оны II улирлын үр дүнгээс 30 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүний үр дүнд 646 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаад байна. Бид 4,300 гаруй даатгуулагчдад нийт 5 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосноор нийт хөрөнгө 2022 оны мөн үеийнхээс 11 хувиар өсөж, 40 тэрбум төгрөгт хүрэв.

Нэгдлийн хэмжээнд жил бүр зохион байгуулдаг Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулганы үеэр MSE: AIC хувьцаа эзэмшигчдэдээ тайлангаа танилцуулж, АрдКойны урамшууллыг хувь тэнцүүлэн олгов.



Ардын Тэтгэврийн Данс

Компани эхний хагас жилд харилцагчдынхаа тоог 8 хувиар нэмэгдүүлж, 146,396-д хүрсэн бол тэтгэврийн хуримтлалын дүн 32 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 43 хувиар өсөв. 2023 оны 1 сараас эхлэн ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог компанид нэвтрүүлж, 34 бодлого, журам боловсруулж, нэвтрүүлэх ажлын хүрээнд 54 бүртгэлийг бий болгосноор Монгол Улсын Стандарт хэмжилзүйн агентлагаас хийсэн шалгалтын дагуу 2023 оны 7 сард гэрчилгээжүүлэх шаардлагыг 3 жилээр хангаж чадлаа.

Ардын Тэтгэврийн Данс нь 2023 оны 2 сард эрсдэлийн удирдлагын бүтцийг бий болгож, тухайлсан бодлогын баримт бичгүүдийг боловсруулан баталсны дагуу компанийн үнэлгээг улирал тутам хийж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт, шинжилгээг нэмэгдүүлэн ажиллаж байна.

(сая төгрөг)	Гол үзүүлэлт	2022 Н1	2023 Н1	YoY
Ард Даатгал	Нийт хөрөнгө	36,143	40,027	10.7%
	Нийт хураамжийн орлого	11,079	14,264	28.7%
	Нийт нөхөн олговор	4,005	27.2%	(35.2%)
Ардын Тэтгэврийн Данс	Тэтгэврийн хуримтлалын нийт өгөөж	1,242	1,978	59.26%
	Хөрөнгө оруулалтын багц	(37,704)	32,596	(13.55%)
	Тэтгэврийн хуримтлал	22,233	31,728	42.71%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР

Ард Секюритиз

2023 оны II улирлын байдлаар Ард Секюритиз Монголын Хөрөнгийн Бирж дээр 32.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг зуучилснаас 9.7 тэрбум төгрөгийн арилжаа нь Ард Аппаар дамжин хийгджээ. Андеррайтинг, санхүүгийн зөвлөх үйлчилгээний хүрээнд Хөх Тэнгэр Төсөл, Ард Кредитын FPO, Атмор бондын бүтээгдэхүүнтэй хамтран ажиллаж байна. Түүнчлэн, Ухаалаг Хөрөнгө Оруулагч, Баялгийн менежмент зэрэг шинэ үйлчилгээг амжилттай нэвтрүүлэн 1,000 гаруй үйлчлүүлэгчид хөрөнгө оруулалтын багцыг үүсгээд байгаа бол онцгойлон Гацуурт ХХК, Ард Кредит ХК-ын хамтран гаргасан бондууд бүрэн төлөгдөж дууссаныг дуулгахад таатай байна.

Ард Менежмент

Энэ оны II улирлын байдлаар Үндэсний Хувьчлалын Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ өмнөх улиралтай харьцуулахад 4.8 хувиар өсөж, Монголын Хөрөнгийн Бирж дэх тус сангийн арилжаа 222 сая төгрөгт хүрээ.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд Ард Аппаар дамжуулан хагас тэрбум төгрөгийн нэгж эрхийн арилжааг гүйцэтгэсэн ба хувьцаа эзэмшигчдийн тоо тогтмол нэмэгдсээр байна. Олон нийтэд сангийн нэгж эрхийг санал болгосноор сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ өмнөх улирлаас 15.2 хувиар өссөн байна.



Ард Пропертиз

Үл хөдлөх хөрөнгийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийснээр Блю Скай Тауэрын 9 давхрыг бүхэлд нь худалдан авч, 1,455 м.кв талбайд засвар тохижилт хийж гүйцэтгэн урт хугацааны түрээсийн гэрээ байгуулж, блокчэйн технологид суурилсан BS9 токен эзэмшигчдийнхээ бүтээгдэхүүнийг Айдас бирж дээр амжилттай байршуулан эхний түрээсийн орлогоо хуваарилж эхэллээ.

(сая төгрөг)	Санхүүгийн үзүүлэлт	2022 H1	2023 H1	YoY
Ард Секюритиз	Нийт арилжаа	42,611	32,233	(24.4%)
	Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө	24,410	25,051	
	Харилцагчийн тоо	148,799	154,099	
Ард Менежмент	Нийт хөрөнгө	7,987	3,159	(60.4%)
	Эздийн өмч	6,996	2,739	(60.8%)
	Удирдлагад буй хөрөнгө	6,345	8,819	39.0%

КРИПТО ҮНДЭСТЭН АРД ВЕНЧУРС

Ард Бит


Зах зээл дээрээс худалдаж авсан болон нөөцөөс нийт 300 сая АрдКойныг шатааж, Ардын Эрх буюу хуримтлалд суурилсан урамшууллын хөтөлбөрийн нөхцөлийг өөрчилөн жилд 10,000 Ардын Эрх цуглуулдаг байсан зарчмыг сард 1,000 Ардын Эрх цуглуулдаг болгон өөрчилснөөр 83 мянган харилцагч 9.9 сая Ардын Эрхийг цуглуулжээ.

The NU in the Metaverse тоглолтын тасалбар, хамтлагийн гишүүдийн дүр болон хөдөлгөөний NFT-г АрдКойноор авах боломжийг бүрдүүлэв. idax бирж дээр BS9 болон форвард хэлцлүүдийн токеныг АрдКойноор эзэмших 9 хослол нээж, АрдКойн олборлогч аяны хүрээнд 1 сая удаагийн гүйлгээгээр 123.2 сая АрдКойныг урамшуулаар олгов. Форвард хэлцлүүдийг сар бүр зарлаж, зах зээл дээрээс 254 сая АрдКойныг 9 удаагийн Форвард хэлцлээр амжилттай татан төвлөрүүлээд байна.

idax

idax бирж энэ оны эхний хагас жилийн байдлаар 160,246 бүртгэлтэй хэрэглэгчтэй болсон бол тэдний 73,589 нь арилжаанд тогтмол идэвхтэй оролцож байна. Хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагын дагуу Tier 2 түвшний хэрэглэгчийн баталгаажуулалтыг нэвтрүүлж, Peer-to-Peer (P2P) арилжааны функц, 10 шинэ Spot арилжааны хослол, Фьючерс арилжааны 23 хослолыг нэмээд байна.

Бирж нь Peer-to-Peer (P2P) арилжааны функцыг нэвтрүүлэхийн зэрэгцээ аюулгүй байдлын хувьд MNS ISO/IEC 27001:2021 II шатны аудитыг амжилттай давж, мэдээллийн аюулгүй байдлын менежментийг тууштай хэрэгжүүлж буйг илтгэв.




Дайверс Солюшнс

Зах зээл дээр хэрэгжиж буй 11 төслөө үргэлжлүүлэхээс гадна 6 шинэ төслийг боловсруулж буйгаас 4 нь web2-тэй холбоотой бол бусад нь web3 төсөл юм. Түүнчлэн, “Эрчим хүчний хэмнэлтийн даатгал” туршилтын төслийг амжилттай боловсруулж, шинэ frontend хөгжүүлснээр idax-ийн ачаалах хугацааг 12 дахин хурдасгав.

2023 оны 4 сард АрдМааний нь платформын үйл ажиллагаандаа хяналт тавьж, салбарын стандартын хэрэгжилтийг хангах үүрэгтэй мэргэжилтнүүдээс бүрдсэн АрдМааний Guardian Зөвлөлийг байгууллаа. Guardian зөвлөл нь АрдМааний экосистемийн ил тод байдал, аюулгүй байдал, итгэлцлийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

МетаФорс

Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Хү хамтлагийн Метаверс дэх дэлхийн анхны Рок тоглолт "The HU in the Metaverse"-ыг зохион байгуулав. Монголчууд хамтран бүтээсэн түүхэн үйл явдлыг нийт баг, хамт олноороо гэрчилж, дэлхийн өнцөг булан бүрт суугаа Хү хамтлагийн фэнүүдэд Америк, Ази 2 цагийн бүсэд амжилттай хүргэж чадлаа. Төрийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэхээр Дижитал хөгжил, харилцаа холбооны яамтай гэрээ байгуулав.



МОСТ Финтек

МОСТ-ын хувьд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж, IPO хийх зорилгын хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл хүлээж байгаа бөгөөд UBХ бирж дээр хийгдэх анхны IPO, Монголын ууган финтек компанийн IPO гэх түүхэн үйл явдлууд нэгэн зэрэг тохиох мөч ойртсоор.

Төлбөр тооцооны платформын хувьд үйлчилгээгээ нийт 7 банк, үүнээс Монгол Улсын шилдэг 5 банкны 3-т, 29 ББСБ шинээр нэвтрүүлж чадсанаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харилцагч Банк, ББСБ-ын тоо 2 дахин нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн тоо 1.6 саяд хүрээд байна.

(сая төгрөг)	Санхүүгийн үзүүлэлт	2022 H1	2023 H1	YoY
	Нийт хөрөнгө	8,563.97	11,282	31.7%
МОСТ Финтек	Эздийн өмч	8,035	10,593	31.8%
	Нийт орлого	712	858	20.5%

ГРЭЙПСИТИ МОНГОЛ

ГрэйпСити нь 2023 оны эхний хагаст арилжааны 13 банкаас 11-д нь банкны програм хангамжийн шийдэл, үйлчилгээ үзүүлдэгээрээ салбартаа тэргүүлэх байр сууриа хадгалсаар байна. Мөн энэ хагаст бид Cloud суурилсан Polaris банкны системийг 14 ББСБ, 5 ХЗХ болон 9 бичил санхүүгийн байгууллагад амжилттай нэвтрүүлжээ.

Эхний хагас жилд COSMOS төсөл - DeFi блокчэйн платформ хөгжүүлэлт, кодгүй, хиймэл оюун ухаан загварчлалын платформ, онлайн худалдаа болон бусад платформуудад зориулсан санал болгох функцуудэд анхааран ажилласнаас гадна NSPP ХХК-ийн 20 хувийг эзэмших болов. NSPP ХХК нь цахим худалдааны зах зээл, мэргэжлийн нийгэмлэг байгуулах платформ, эрүүл мэндийн дижитал үйлчилгээний платформ, AI чатбот хөгжүүлэгч юм.

	Санхүүгийн үзүүлэлт	2022 H1	2023 H1	YoY
ГрэйпСити Монгол	Нийт хөрөнгө	3,937	6,700	70.2%
	Эздийн өмч	2,809	4,151	47.8%
	Нийт орлого	3,658	4,206	15.0%

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

	Санхүүгийн үзүүлэлт	2022 H1	2023 H1	YoY
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	Нийт хөрөнгө	17,641	17,744	0.6%
	Эздийн өмч	13,385	14,347	7.2%
	Нийт орлого	0	12	1,100.0%




НЭГТГЭСЭН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

	2020	2021	2022	2023 Н1	YTD
Нийт компани	31	38	44	45	1
Нийт ажиллагсад	223	335	276	261	(15)
Хувьцаа эзэмшигч	12,296	62,418	59,109	56,421	(2,688)
Ард Апп хэрэглэгч	637,000	990,071	1,055,828	1,112,723	56,895
АрдКидс апп хэрэглэгч	-	22,113	36,921	49,539	12,618
АрдКойн эзэмшигч	286,117	516,425	543,538	416,023	(127,515)
Зээлийн данс (идэвхтэй)	7,677	21,149	9,702	21,768	12,066
Даатгуулагч (идэвхтэй)	74,947	86,089	105,816	103,918	(1,898)
Тэтгэврийн хуримтлал эзэмшигч	10,447	100,600	134,684	146,396	11,712
Үнэт цаасны данс эзэмшигч	89,305	146,893	151,651	154,063	2,412
Ард Актив ХЗХ-ны гишүүн	1,062	2,678	2,819	3,340	521
Тусгай зөвшөөрөл	37	43	44	45	1

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

Банк

36%



Лизинг



Даатгал

21%



Амьдралын даатгал



Хөрөнгө Оруулалтын Банк

11%



ХОМК



Бусад

20%



Технологи

13%




Медиа нэгдэл



Програм хангамж



Хаалттай сан



Нээлттэй сан



Үнэт цаасны бирж



Төлбөрийн платформ



● Ард Санхүүгийн Нэгдэл
● Холбоотой этгээд

▲ Нээлттэй компани

Нэгтгэсэн хөрөнгөд эзлэх хувь

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

MSE:AARD

Хувьцаа эзэмшигч	2023/3/31	%	2023/6/30	%	Өөрчлөлт	%
И Ай Ти	3,279,564	11.46%	3,128,670	10.93%	(150,894)	(0.53%)
Бруно Рашле	2,109,997	7.37%	2,109,997	7.37%	0	0.00%
А.Сүхдорж	1,944,990	6.80%	1,944,990	6.80%	0	0.00%
Ардын Тэтгэврийн Данс	1,648,197	5.76%	1,764,353	6.17%	116,156	0.41%
Ч.Ганхуяг	1,539,702	5.38%	1,576,442	5.51%	36,740	0.13%
Голомт Кастадион банк	1,426,087	4.98%	1,526,910	5.34%	100,823	0.35%
Айдакс	799,177	2.7%	900,000	3.1%	100,823	0.3%
Ардын Тэтгэврийн Данс	626,910	2.1%	626,910	2.1%	0	0.0%
Ард Венчурс	1,507,849	5.27	1,498,647	5.24%	(9,202)	(0.03%)
Г.Уянга	1,389,739	4.86%	1,389,754	4.86%	15	0.00%
Ард Лизинг	745,084	2.60%	631,621	2.21%	(113,463)	(0.40%)
С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.59%	0	0.00%
Ронк Лимитед	443,816	1.55%	443,816	1.55%	0	0.00%
Ард Секюритиз	445,164	1.56%	408,209	1.43%	(36,955)	(0.13%)
Ард Бит	196,796	0.69%	400,460	1.40%	203,664	0.71%
С.Оргил	390,937	1.37%	390,937	1.37%	0	0.00%
Г.Бат-Эрдэнэ	351,268	1.23%	351,268	1.23%	0	0.00%
Н.Мөнхнасан	344,311	1.20%	344,311	1.20%	0	0.00%
Масик Энтерпрайзес	321,078	1.12%	321,078	1.12%	0	0.00%
Ард Даатгал	405,387	1.42%	253,265	0.89%	(152,122)	(0.53%)
Ард Кредит	248,729	0.87%	249,019	0.87%	290	0.00%
Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.82%	0	0.00%
Топ 20	19,427,933	67.90%	19,422,985	67.88%	(4,948)	0.34%
Бусад	9,186,330	32.10%	9,191,278	32.12%	4,948	(1.02%)
Эргэлтэд буй хувьцаа	28,614,263	100%	28,614,263	100%	-	0
Халаасны хувьцаа						
Нийт гаргасан хувьцаа	28,614,263				-	-
Хувьцаа эзэмшигчид	19,096		19,301		205	
ARDT эзэмшигчид	3,030		3,064		34	

ОРЛОГЫН ТАЙЛАН

(сая төгрөг)	2022 У2	2022 У4	2023 У2	2023 У2 (В)	YoY	YTD
Хөрөнгө оруулалтын орлого		3,657		3,500		(100.0%)
Ногдол ашгийн орлого	965	1,012			(100.0%)	(100.0%)
Хүүгийн орлого	449	18	344		(23.3%)	1,787.9%
Менежментийн орлого	1,455	2,837	941	1,501	(35.3%)	(66.8%)
Түрээсийн орлого	1,000	1,886	1,061	702	6.1%	(43.8%)
Бусад орлого	498	4,365	401		(19.5%)	(90.8%)
НИЙТ ОРЛОГО	4,367	13,776	2,747	5,703	(37.1%)	(80.1%)
Санхүүгийн зардал	1,728	3,160	1,321	789	(23.6%)	(58.2%)
Цалингийн зардал	798	1,594	643	1,238	(19.4%)	(59.7%)
Үйл ажиллагааны зардал	3,214	7,933	4,750	2,528	47.8%	(40.1%)
НИЙТ ЗАРДАЛ	5,739	12,688	6,713	4,555	17.0%	(47.1%)
Гадаад валютын ханшийн						
зөрүүний олз (гарз)	(45)	(31)	5		111.2%	116.3%
Бусад олз (гарз)	(208)	1,234				(100.0%)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	(1,626)	2,291	(3,961)	1,149	(143.7%)	(272.9%)
Орлогын албан татварын						
зардал	(890)	180	38	0	104.3%	(78.6%)
ЦЭВЭР АШИГ	(736)	2,111	(3,999)	1,149	(443.6%)	(289.5%)
Хөрөнгө оруулалтын үнэлгээний						
олз (гарз)	(51,500)	(155,722)	(10,514)	0	79.6%	93.2%
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	(52,236)	(153,612)	(14,513)	1,149	72.2%	90.6%

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(сая төгрөг)	2022 У2	2022 У4	2023 У2	2023 У2 (В)	YoY	YTD
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	409	4	3	2,454	(99.0%)	(16.0%)
Дансны болон бусад авлага	19,779	21,735	23,314	18,775	17.9%	7.3%
Урьдчилж төлсөн зардал/тооцро	4,570	4,644	4,415	1,190	(3.4%)	(4.9%)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	20	366	691	22	3,371.6%	88.7%
Виртуал хөрөнгө	53,893	11,833	11,072	11,511	(79.5%)	(6.5%)
Биет бус хөрөнгө	195	187	180	80	(7.3%)	(3.5%)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	189,439	96,138	88,983	190,555	(53.0%)	(7.4%)
Үндсэн хөрөнгө	2,442	1,700	1,390	1,158	(43.1%)	(18.3%)
НИЙТ ХӨРӨНГӨ	270,746	136,608	130,048	225,746	(52.0%)	(4.8%)
Дансны болон бусад өглөг	14,494	3,854	13,853	14,760	(4.4%)	259.4%
Татварын өглөг	1,425	1,218	659	31	(53.8%)	(45.9%)
Санхүүгийн түрээсийн өглөг	226			4,700	(100.0%)	
Урьдчилж орсон орлого	9,379	9,966	11,552	1,606	23.2%	15.9%
Богино хугацаат өр төлбөр	2,629	2,578	2,619	528	(0.4%)	1.6%
Бондын өр төлбөр	2,886	2,603	1,020	420	(64.7%)	(60.8%)
Урт хугацаат зээл	7,692	6,590	6,229	2,198	(19.0%)	(5.5%)
Хойшлогдсон татварын өр	18,443	6,187	5,019	15,189	(72.8%)	(18.9%)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	57,175	32,996	40,950	39,433	(28.4%)	24.0%
Өмч-хувьцаат	28,614	28,614	28,614	28,614		
Нэмж төлөгдсөн капитал	2,928	2,928	2,928	2,928		
Хуримтлагдсан ашиг	19,168	19,264	15,264	20,569	(20.4%)	(20.8%)
Дахин үнэлгээний нөөц	162,847	52,793	42,279	134,189	(74.0%)	(19.9%)
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14	14		
ЭЗДИЙН ӨМЧ	213,571	103,612	89,099	186,313	(58.3%)	(14.0%)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	270,746	136,608	130,048	225,746	(52.0%)	(4.8%)


ҮНЭЛГЭЭ

Хувьцаа эзэмшигч	Суурь	2021	%	2022	%	2023 Н1	%	YTD
Стратегийн хөрөнгө оруулалт		397,699		109,972		102,030		(7%)
Ард Даатгал (MSE: AIC)	MV	14,970	45%	10,535	45%	9,430	45%	(10%)
Ард Кредит (MSE: ADB)	MV	25,009	41%	14,630	41%	15,143	41%	4%
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	31,727	24%	19,907	20%	18,406	20%	(8%)
Ард Секюритиз	BV	15,756	90%	4,946	90%	4,858	90%	(2%)
Ард Менежмент	BV	6,708	90%	1,934	90%	2,613	90%	35%
Ард Актив	BV	741	9%	780	10%	845	10%	8%
Ардын Тэтгэврийн Данс	BV	33,217	95%	9,510	95%	9,510	95%	0%
Ард Лизинг	BV	5,256	100%	1	100%	1	100%	0%
Тэнгэр Системс	BV	9,950	100%	1,076	100%	1,076	100%	0%
Ард Венчурс	BV	15,002	100%	0	0%	0	0%	
Ард Пропертиз	BV	34,965	100%	4,127	100%	4,127	100%	0%
Ард Бит	BV	84,023	100%	0	0%	0	0%	
DAX	DCF	45,000	60%	0	0%	0	0%	
Даац Инвестмент	Cost	4,096	51%	4,096	51%	4,096	51%	0%
ТэнгэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR)	MV	57,780	48%	38,430	38%	31,925	38%	(17%)
Грэйпсити Монгол	Cost	9,000	45%					
МОСТ Финтек	Cost	4,500	45%					
Тактикийн хөрөнгө оруулалт		15,729		1,173		1,361		16%
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: ХОС)	MV	19	0%	26	1%	26	1%	0%
КриптоҮндэстэн	MV	5,319	28%	589	6%	338	4%	(43%)
Бусад санхүүгийн хэрэгслүүд		10,391		558		997		79%
Бусад		40,137		24,736		17,054		(31%)
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө		62,155		13,722		12,643		(8%)
Бэлэн мөнгө		331		4		3		(25%)
Бусад цэвэр хөрөнгө		(22,349)		11,010		4,408		(60%)
Нийт үнэлгээ		453,565		135,881		120,445		(11%)
Нэгж хувьцааны үнэлгээ		15,851		4,749		4,209		(11%)

ЭРСДЭЛ & АУДИТ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Ард Санхүүгийн Нэгдэл нь үндсэн 3 кластер болох Банкны, Хөрөнгө Оруулалтын Банкны, Даатгалын кластерууд дахь компаниудынхаа үйл ажиллагааг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарч, эрсдэлийн удирдлага-хянан нийцүүлэлт-дотоод хяналтын чиглэлээр тогтмол зөвлөмж өгч, компани бүрийн эрсдэлийн нэгжтэй хамтран ажилладаг.



Эрсдэлийн төрөл Эрсдэлийн үнэлгээний аргачлал

Зах зээлийн эрсдэл	VaR (Value at Risk) - хамгийн их эрсдэлийн аргаар эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг
Хөрвөх чадварын эрсдэл	Мөнгөн урсгалын шинжилгээ, Базелийн LCR (Liquidity coverage ratio) NSFR (Net stable funding ratio)-г тогтмол хэмжин, тайлагнаж, дүгнэлт зөвлөмж өгдөг
Зээлийн эрсдэл	Зээлийн багцын эрсдэл тооцох, кредит скоринг болон бусад энгийн загваруудыг ашиглан зээлийн эрсдэлийг тооцоолон дүгнэлт зөвлөмж өгдөг
Хүүний эрсдэл	Эргэн төлөгдөх хугацааны загвар, EVE болон бусад үзүүлэлтүүдээр тогтмол хэмжин, тайлагнаж, дүгнэлт зөвлөмж өгдөг.
Валютын ханшийн эрсдэл	Ханшийн тэгшитгэлээс үүсэх алдагдал болон нээлттэй позицын эрсдэлээр жигнэсэн активд үзүүлэх нөлөөг хамгийн их эрсдэл - Value at Risk (VaR) аргаар тооцдог





АУДИТ

2023 оны эхний хагас жил аудитын хувьд хөндлөнгийн аудит хийлгэх чухал үе бөгөөд Группын хэмжээнд дараах компаниудтай хамтран ажилласан байна.

Кластер	Банк: Ард Кредит, Ард Актив, Ард Лизинг	Даатгал: Ард Даатгал, Ардын Тэтгэврийн Данс	Хөрөнгө Оруулалтын Банк: Ард Секюритиз, Ард Менежмент
Аудитын компани	Грант Торнтон, Ачуут Хүлэг	Грант Торнтон	Грант Торнтон
Дүгнэлт	Тайланд өөрчлөлт оруулаагүй	Тайланд өөрчлөлт оруулаагүй	Тайланд өөрчлөлт оруулаагүй

Жич: Компаниудын аудитлагдсан тайланг нээлттэй компаниуд Монголын Хөрөнгийн Биржийн вэбсайт, бусад компаниуд өөрийн вэбсайтад байршуулсан байгаа тул та бүхэн дэлгэрэнгүй тайлантай танилцах, санал шүүмжээ илэрхийлэх бүрэн боломжтой.

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



Тикер	2023 Ү2 (улирлын)		52-долоо хоног		2023 Ү2 (улирлын)		52-Долоо хоног		2023/6/30	
	Дээд	Доод	Дээд	Доод	Арилж ааны дүн	Эргэц %	Арилж ааны дүн	Эргэц %	Хаалт ын ханш	33Ү
AARD	3,649	3,000	5,545	2,913	2.56 B	2.79%	9.54 B	9.30%	3,403	97.37 B
AIC	860	681.1	997	681.1	0.53 B	2.50%	1.72 B	8.26%	831.39	20.79 B
ADB	139	97	139	97	0.69 B	2.19%	1.34 B	4.44%	133.22	37.27 B
MNP	975	657.2	975	657.2	0.10 B	0.13%	4.14 B	5.98%	919.37	91.56 B
TNGR	12,000	7,700	17,000	7,700	0.26 B	0.48%	0.64 B	1.04%	11,920	71.52 B
CNF	80,000	51,500	90,720	40,000	0.25 B	3.04%	1.74 B	28.04%	74,500	8.34 B
МХБ-д эзлэх %					4.41%		7.45%		3.28%	

MSE: 

MSE: 

MSE: 

MSE: 


MSE: 

MSE: 

Хүчтэй. Хамтдаа.

 7700 3322

 ardholdings.com

 Сентрал Тауэр, 17 давхар,
Сүхбаатарын талбай-2, 8-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол улс